



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/551

Эрдэнэт

Устгалын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.8 дахь заалт, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн "ариутгал, халдваргүйтгэл хийлгэх тухай" 2018 оны 14-03-041/121 дүгээр дүгнэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Эрдэнэт хотын нийтийн болон дундын өмчлөлийн талбай, орон сууцны суурин давхаруудад /нохой бөөс үүрлээд байгаа/ цэвэрлэгээ үйлчилгээ, халдваргүйтгэл, шавьжгүйтгэлийн ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 2018 оны 9 дүгээр сарын 14-ний хооронд зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг стандарт аргачлалын дагуу техник хэрэгслийг ашиглан үр дүнтэй хийж гүйцэтгэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/-т, үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбоод болон байгууллага, аж ахуй нэгжүүдийг бүрэн хамруулж ажиллахыг Баян-Өндөр сумын Засаг дарга С.Ганцогт, орон сууцны суурин давхаруудад цэвэрлэгээ үйлчилгээ, халдваргүйтгэл, шавьжгүйтгэл хийхэд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг Сууц өмчлөгчдийн холбоодын дарга нарт тус тус үүрэг болгосугай.


3.Устгалын ажилд шаардагдах 36500000 /гучин зургаан сая таван зуун мянган/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталж, болзошгүй аваарын зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/, Мэргэжлийн хяналтын газар /н.Жигдэнгомбо/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc
J201802931

Аймгийн Засаг даргын 2018 оны
 5.5 дүгээр сарын 12-ны өдрийн
 5.5 дугаар захирамжийн хавсралт



УСТГАЛ ХИЙХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Тайлбар
1	Ариутгалын бодис	л	825	40000	33000000	Нийт 362.4 мян/м ² талбайд шавьж устгал хийнэ. Үүнд: -Орон сууц-117 орон сууц 197,4 мян/м ² , 558 подволь, сургууль цэцэрлэг, нийтийн эзэмшлийн талбай-165.0 мян/ м ² -1 м ² талбайд 2 гр бодис орох нормоор тооцсон.
2	Хөдөлмөр хамгаалын хувцас	ш	140	13500	1890000	Нийт 8 хун ажиллана. Өдөрт 1 хувцас өмснө. 2 хувцас болзошгүй тохиолдолд хэрэглэх.
3	Шаардлагатай үед хэрэглэх эм	багц	12 нэр төрлийн эм	1	170400	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн даргын 2017 оны А/80 дугаар тушаалын хавсралт
4	Шатахуун /машин, помп/	л	560	2160	1209600	Ажлын уусмал тээвэрлэх машин, уусмал бороожуулах помп өдөрт 40 литр х14 хоног 560 л дизель түлш зарцуулна.
5	Хор саармагжуулах бүтээгдэхүүн	ш	112	2500	280000	Өдөрт 1 сүү, тараг хэрэглэнэ.
ДҮН					36500000	

Жич: Баян-Өндөр сумын 22 СӨХ-ны 117 байрны 558 подвалийн нийт 197,4 мянган м² талбай, 8 сургууль, цэцэрлэгийн 75,0 мянган м² талбай, гадна эзэмшлийн талбай 90,0 мянган м² буюу нийт 362,4 мянган м² талбайд шавьж устгалын арга хэмжээг зохион байгуулна.